



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2022 оны 07 сарын 25 өдөр

Дугаар A/386

Улаанбаатар хот

Магадлан итгэмжлэл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн 2022 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн 13 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын нэрсийг хавсралтаар баталж, батламжийг олгосугай.

2. Магадлан итгэмжлэлийн хугацаа тасарч сунгагдаж буй эрүүл мэндийн байгууллагуудын магадлан итгэмжлэл эхлэх хугацааг 2022 оны 7 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн тооцугай.

3. Магадлан итгэмжлэлийн хугацаанд тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах ажлыг тасралтгүй зохион байгуулж, шинжээчдийн багийн өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

4. Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн 2022 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн 13 дугаар хурлын шийдвэрийг холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төрийн захиргаа удирдлагын газар /П.Эрхэмбаяр/-т, Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/ -д тус тус үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /С.Төгсдэлгэр/-т даалгасугай.

САЙД



С.ЭНХБОЛД

141221870

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 07 дугаар сарын 29-ны өдрийн 4/386 дугаар тушаалын хавсралт

МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭРС

№	Эрүүл мэндийн байгууллагын нэрс	Батламжийн Дугаар	Магадлан итгэмжлэгдсэн хугацаа	Магадлан итгэмжлэл эхлэх огноо	Магадлан итгэмжлэл дуусах огноо
1.	Сонгинохайрхан, Ээлтэй өрхийн эрүүл мэндийн төв	244/2022	4 жил	2022.08.05	2026.08.05
2.	Ачит эх мед ХХК-ийн эмнэлэг	245/2022	2 жил	2022.08.17	2024.08.17
3.	Лона ХХК-ийн сувиллын газар	246/2022	2 жил	2022.08.05	2024.08.05
4.	Монгол фарм дистрибьюшн ХХК-ийн эмнэлэг	247/2022	2 жил	2022.07.25	2024.07.25
5.	Сэрсандимэд ХХК-ийн эмнэлэг	248/2022	4 жил	2022.07.30	2026.07.30
6.	Филошийп ХХК-ийн эмнэлэг	249/2022	2 жил	2022.08.05	2024.08.05
7.	Эрхэм чанар-Эрдэнэ ХХК-ийн Нандин-Эрдэнэ Сэргээн засах төв	250/2022	1 жил	2022.07.25	2023.07.25
8.	Архангай аймаг, Хайрхан сумын эрүүл мэндийн төв	251/2022	1 жил	2022.07.25	2023.07.25
9.	Баянхонгор аймаг, Баянбулаг сумын эрүүл мэндийн төв	252/2022	3 жил	2022.08.01	2025.08.01
10.	Баянхонгор аймаг, Өлзийт сумын эрүүл мэндийн төв	253/2022	3 жил	2022.08.01	2025.08.01
11.	Баянхонгор аймаг, Гурванбулаг сумын эрүүл мэндийн төв	254/2022	2 жил	2022.08.01	2024.08.01
12.	Булган аймаг, Бүрэгхангай сумын эрүүл мэндийн төв	255/2022	3 жил	2022.07.25	2025.07.25
13.	Булган аймаг, Рашаант сумын эрүүл мэндийн төв	256/2022	2 жил	2022.07.25	2024.07.25
14.	Булган аймаг, Цоожид өрхийн эрүүл мэндийн төв	257/2022	3 жил	2022.07.25	2025.07.25
15.	Говь-Алтай аймаг, Машид-Эрдэнэ ХХК-ийн сэргээн засах төв	258/2022	2 жил	2022.07.27	2024.07.27
16.	Хэнтий аймаг, Дэлгэрхаан сумын эрүүл мэндийн төв	259/2022	1 жил	2022.07.25	2023.07.25
17.	Хэнтий аймаг, Тахилгат тосгоны эрүүл мэндийн төв	260/2022	2 жил	2022.07.25	2024.07.25
18.	Хэнтий аймаг, Чингисийн гурван нуур ХХК-ийн сувилал	261/2022	1 жил	2022.07.25	2023.07.25